



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/113

Мандалговь

Шагнаж, урамшуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.4, аймгийн Засаг даргын 2017 оны А/407 дугаар захирамжаар батлагдсан “Шилдэг төрийн албан хаагч шалгаруулж, урамшуулах журам”-ын 4.3 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 тоот тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 5 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2019 оны аймгийн “Шилдэг төрийн албан хаагч”-аар нэр бүхий 2 эмчийг журмын дагуу шалгаруулж тус бүр өргөмжлөл 1,000,000 төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

Хоёр. Шилдэг төрийн албан хаагчаар шалгарсан эмч нарын нэрсийг 1 дүгээр, урамшууллын зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. Шагналын зардалд шаардагдах 2.140.000 (Хоёр сая нэг зуун дөчин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190323



Аймгийн Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн /113/ тоот захирамжийн 1 дүгээр хавсралт

“ШИЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ”-ААР ШАЛГАРСАН ЭМЧ НАРЫН НЭРС

№	Овог нэр	Албан тушаал
1	Жамьян Энхжаргал	Нэгдсэн эмнэлэг Чанарын албаны дарга
2	Цэрэнням Элбэгмаа	Нэгдсэн эмнэлэг поликлиникийн тасагт наркологийн эмч

Аймгийн Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын  
21-ний өдрийн 113 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

“ШИЛДЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ” НАРЫГ УРАМШУУЛАХ, УРАМШУУЛЛЫН ЗАРДАЛ

№	Зардлын утга	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Урамшуулал	2	1000000	2,000,000
2	Хүндэт өргөмжлөл	2	65000	130,000
3	Батламж	2	5000	10000
	ДҮН			2,140,000